



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/486

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан “Манлайлагч ахмадууд” чуулга уулзалт хүндэтгэлийн арга хэмжээний хүрээнд сум бүрээс ахмад настан алдаршуулах зардалд 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсаргав.

3. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 09 дугаар сарын 22-ны
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Сум бүрээс нэг ахмад настныг алдаршуулах зардал	22	100,000	2,200,000
Нийт				2,200,000